



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/104

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ардын хувьсгалын 100 жил, Ховд хотын 90 жилийн ой, Эх орончдын өдрийг тохиолдуулан Ховд хот байгуулагдсан он цагаас эхлэн түүхээ эргэн харж, хөгжил дэвшил, алдаа оноо, ололт амжилтаа дүгнэн хэлэлцэх, түүнийг дүрс бичлэг, богино хэмжээний бүтээл болгон олон нийтэд түгээх зардалд 1 000 000 төгрөг /Нэг сая/-ийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээний зардалд зарцуулагдах 1 000 000 төгрөг /Нэг сая/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн 4.1 тусгагдсан Хэвлэл мэдээллийн тогтвортой хөгжлийг дэмжих хөтөлбөрөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ